



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

641.	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2338
642.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2345
643.	Хэлэлцээр соёрхон батлах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	2345
644.	Хэлэлцээр соёрхон батлах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	2346
645.	Хэлэлцээр соёрхон батлах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	2346
646.	Хэлэлцээр соёрхон батлах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	2347
647.	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2347
648.	Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2348

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

649.	Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай	Дугаар 98	2348
650.	Үндэсний бахархалт шувууг зарлах тухай	Дугаар 101	2376



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 10 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тамхины хяналтын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.7- 3.1.10 дахь заалт:

“3.1.7. “тамхигүй орчин” гэж тамхи татах, тамхины утааг харах, үнэрлэх, мэдрэх, хэмжих боломжгүй орчныг;

3.1.8. “дотоод орчин” гэж дээвэр, хана, талуудаар хүрээлэгдсэн орон зай (хийсэн материал, тухайн орон зайг түр хугацаанд буюу байнга ашиглахаас хамаарахгүй)-г;

3.1.9. “брэнд өргөтгөх” гэж тамхи, тамхин бүтээгдэхүүний нэр, барааны тэмдэг, лого зэрэг бусад ялгарах онцлогийг тамхин бус бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой мэтээр ашиглахыг;

3.1.10. “брэнд хуваалцах” гэж тамхин бус бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, барааны тэмдэг, лого зэрэг бусад ялгарах онцлогийг тамхи, тамхин бүтээгдэхүүн, тамхи үйлдвэрлэгчтэй холбоотой мэтээр ашиглахыг.”

2/4 дүгээр зүйлийн 4.1.5-4.1.9 дэх заалт:

“4.1.5. тамхи үйлдвэрлэгч, түүний ашиг сонирхлын төлөө ажиллаж байгаа хуулийн этгээдийг нээлттэй, хариуцлагатай зарчмаар үйл ажиллагаагаа явуулахыг шаардах;

4.1.6. тамхи үйлдвэрлэгчийн үйл ажиллагаанд урамшуулал, татварын хөнгөлөлт болон бусад давуу тал олгохгүй байх;

4.1.7. тамхины хяналтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тамхи үйлдвэрлэгчтэй өмчийн хэлбэр харгалзахгүйгээр адил тэгш хандах;

4.1.8. тамхи үйлдвэрлэгч, түүний ашиг сонирхлын төлөө ажиллаж байгаа хуулийн этгээдийг тамхины хяналтын талаарх хууль тогтоомж боловсруулах, батлах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шууд оролцох болон хөндлөнгөөс нөлөөлөхөөс ангид байлгах;



4.1.9.нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд тамхи үйлдвэрлэгч хөндлөнгөөс оролцох стратеги, арга, уул бодлогыг тамхи үйлдвэрлэгчийн ашиг сонирхлын нөлөөллөөс хамгаалах шаардлага болон тамхи үйлдвэрлэгчийн зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны талаар төрийн бүх шатны байгууллага, олон нийт мэдээллээр хангагдсан байх.”

3/5 дугаар зүйлийн 5.1.3- 5.1.5 дахь заалт:

“5.1.3.нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, олон нийтийн боловсрол олгох чиглэлээр тамхи үйлдвэрлэгч, эсхүл түүний ашиг сонирхлын төлөө ажиллаж байгаа хуулийн этгээд, иргэдтэй хамтран ажиллахаас татгалзах;

5.1.4.тамхины хяналтын тухай хууль тогтоомж боловсруулах явцад ашиг сонирхлын зөрчил байгаа гэж үзсэн тохиолдолд тамхи үйлдвэрлэгчээс тавьсан саналыг хүлээн авахаас татгалзах;

5.1.5.тамхины хяналтын талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа төрийн албан хаагч, бусад ажилтны ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг шийдвэрлэж, хамтран ажиллахаас татгалзах.”

4/5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт:

“5.2.3.тамхи үйлдвэрлэгчээс төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг хүлээж авахаас татгалзах.”

5/5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг:

“5.3.Тамхины хяналтын талаар тамхи үйлдвэрлэгч хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:

5.3.1.тамхи үйлдвэрлэгч болон түүний 20-оос дээш хувийн хувьцаа эзэмшигчийн нэр, хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа, тамхины үйлдвэрлэлтэй холбоотой бусад мэдээллийг өөрийн цахим хуудаст байрлуулан нийтэд ил тод байлгах;

5.3.2.эрх бүхий байгууллагаас баталсан тамхины хайрцаг, сав, баглаа боодолд тавигдах стандартыг батлагдсан өдрөөс нь хойш нэг жилийн дотор бүрэн хангасан байх.”

6/6 дугаар зүйлийн 6.7.13-6.7.15 дахь заалт:

“6.7.13.интернэтээр тамхи худалдах;



6.7.14.ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдах;

6.7.15.баар, цэнгээний газарт тамхи худалдах.”

7/6 дугаар зүйлийн 6.8, 6.9 дэх хэсэг:

“6.8.Тамхи, тамхин бүтээгдэхүүний худалдаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:

6.8.1.худалдан авагчийн насыг тодорхойлох зорилгоор иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтаа үзүүлэхийг шаардах;

6.8.2.энэ хуулийн 6.8.1-д заасан бичиг баримт үзүүлэхээс татгалзсан бол түүнд тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдахгүй байх.

6.9.Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.”

8/8 дугаар зүйлийн 8.1.7-8.1.12 дахь заалт:

“8.1.7.тамхи борлуулах аливаа цэгт тамхины нэр, үнэ, тамхин бүтээгдэхүүнийг биетээр дэлгэн тавихаас бусад хэлбэрээр мэдээлэл өгөх;

8.1.8.тамхины хайрцаг, сав, баглаа боодлын гадна болон дотор талд үндэсний стандартад зааснаас бусад, хэрэглэгчийн анхаарал татах аливаа нэмэлт дүрс, үг хэллэг зэрэг мэдээллийг агуулсан байх;

8.1.9.тамхи үйлдвэрлэгчийн брэнд өргөтгөх болон брэнд хуваалцах үйл ажиллагаа;

8.1.10.тамхи үйлдвэрлэгч өөрөө, эсхүл өөр байгууллага, этгээдээр дамжуулан бусдад санхүүгийн болон эд материалын хандив, тусламж үзүүлэх замаар тамхийг шууд, шууд бус хэлбэрээр сурталчлах;

8.1.11.тамхины брэндийн дүрс, логог үзвэр, үйлчилгээний газрын орчинд байршуулах;

8.1.12.тамхины талаар худал ташаа, төөрөгдүүлсэн, эсхүл буруу сэтгэгдэл төрүүлж болох бүх төрлийн сурталчилгаа.”



9/8 дугаар зүйлийн 8.3, 8.4 дэх хэсэг:

“8.3.Тамхины хил дамнасан зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглоно.

8.4.Тамхи үйлдвэрлэгч шууд, эсхүл өөр байгууллагаар дамжуулан нийгмийн хариуцлага нэрийн дор нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, байгаль орчныг хамгаалах байгууллагад санхүүгийн болон эд материалын хандив, тусламж үзүүлэхийг хориглоно.”

10/13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг:

“13.2.Энэ хуулийн 7.1-д заасныг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулна.”

2 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “Нэг удаад зургаан төрлийн анхааруулгын загвар гаргах бөгөөд анхааруулгын загварыг гурван жилд нэг удаа солино.” гэсэн 2 дахь өгүүлбэр, мөн зүйлийн 6.7.2 дахь заалтын “ширхгээс” гэсний дараа “цөөнөөр, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг 200 граммаас” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “тамхи үйлдвэрлэгчээс” гэсний дараа “эрүүл мэнд, боловсрол,” гэж, мөн зүйлийн 8.2 дахь хэсгийн “Тамхины” гэсний дараа “бүх төрлийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн дараах зүйл, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.2.1, 5.2.2 дахь заалт:

“5.2.1.тамхины хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх, иргэнийг тамхинаас гарахад бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх, дам тамхидалтаас сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

5.2.2.тамхины хэрэглээ, дам тамхидалтын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд учрах эрсдэл, хор нөлөөний талаар шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр иргэдийг хангах;”

2/6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт:

“6.4.1.зурагт анхааруулга нь янжуур тамхины хайрцагны нүүр болон ар талын талбайн хэсгийн, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины сав, баглаа боодлын нүүрэн талын гадаргууны талбайн 50-аас багагүй хувийг эзэлсэн байх;”



3/6 дугаар зүйлийн 6.7.1 дэх заалт:

“6.7.1.тамхины найрлагад агуулагдах бохь, никотин, бусад хорт бодисын хэмжээ болон дуусгавар болох хугацааг заагаагүй,”

4/8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт:

“8.1.1.тамхи, тамхи ороодог цаас, тамхины шүүр, тамхи орооход хэрэглэгддэг төхөөрөмж, тамхины бусад дагалдах хэрэгсэл, тамхи үйлдвэрлэгчийн нэр, лого, тамхин бүтээгдэхүүн, түүний брэндийн нэр, барааны тэмдэг, тамхи үйлдвэрлэгчтэй холбоотой өнгө, өнгөний хослол, үг хэллэг, дизайн, зураг, дүрс, үнэр, дуу авиаг ашиглах, алдартай жүжигчин, тамирчин, урлаг, соёлын ажилтан зэрэг олон нийтийн дунд нэр хүнд бүхий хүнийг оролцуулах замаар тамхийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, хувцасны загвар өмсөх үзүүлбэр, урлаг, спортын тоглолт, уралдаан, тэмцээн, гар утас, бусад шинэ технологи, ханын болон гудамжны самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз ашиглах болон бусад биет байдлаар сурталчлах;”

5/8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт:

“8.1.6.гадна хэлбэрээрээ тамхин бүтээгдэхүүнтэй ижил төстэй чихэр, тоглоом болон тамхин бус бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, үнэгүй бэлэг, бүтээгдэхүүний дээж тараах, аливаа хэлбэрийн сугалаа, уралдаан, тэмцээн, хямдрал, урамшуулал, хөнгөлөлт, тэтгэлэг үзүүлэх зэрэг бусад хэлбэрээр тамхи сурталчлах;”

6/ 9 дүгээр зүйл:

“9 дүгээр зүйл.Утаат тамхи татахыг хориглох

9.1.Дараах газар утаат тамхи татахыг хориглоно:

9.1.1.бүх төрлийн нийтийн тээврийн хэрэгсэл;
9.1.2.олон нийтийн үзвэр, үйлчилгээний газар;
9.1.3.шатахуун түгээгүүрийн газар, шатах, тослох, тэсэрч, дэлбэрэх бодис, материалын үйлдвэр, түүний нөөцийн агуулах;

9.1.4.зорчигч тээврийн буудал, зочид буудлын нийтийн танхим, тамхи татахыг хориглосон өрөө;

9.1.5.нийтийн хоол, худалдаа, баар, цэнгээний газар;



9.1.6.аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны дотоод орчин;

9.1.7.агаарын хөлөг, зорчигч тээврийн галт тэрэг;

9.1.8.цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, тэдгээрийн гаднах орчин, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орц, цахилгаан шат, хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн.

9.2.Аж ахуйн нэгж, байгууллага хуульд заасан тамхины хяналтын үйл ажиллагаатай холбогдсон зохицуулалтыг байгууллагынхаа хөдөлмөрийн дотоод журамд тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

9.3.Аж ахуй нэгж, байгууллагын орох хаалга, хүлээлгийн танхим, хонгил, бие засах газар болон бусад шаардлагатай газарт тамхи татахыг хориглосон анхааруулах тэмдэг байрлуулна.

9.4.Энэ хуулийн 9.3-т заасан анхааруулах тэмдэг нь зөрчил илэрсэн тохиолдолд олон нийтийн мэдээлэл, гомдол, саналыг хүлээн авч шийдвэрлэх байгууллагын хаяг, утасны дугаар, албан тушаалтны нэрийг агуулсан байх бөгөөд анхааруулах тэмдгийн загварыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

7/13 дугаар зүйлийн 13.1.1-13.1.7 дахь заалт:

“13.1.1.энэ хуулийн 6.4, 6.6, 6.7.1-6.7.8, 6.7.10-6.7.12, 6.7.14, 6.7.15, 8.2-т заасныг зөрчсөн бол иргэнийг 50000 төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, тамхи болон хууль бусаар олсон орлого болон сурталчилгааны материалыг хураах;

13.1.2.энэ хуулийн 6.7.9-д заасныг зөрчсөн бол иргэнийг 50000 төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, тамхи болон хууль бусаар олсон орлого болон тамхи худалдах автомат машиныг хураах;

13.1.3.энэ хуулийн 6.7.13-т заасныг зөрчсөн тохиолдолд интернетийн тухайн веб хуудсыг нэг жилээс доошгүй хугацаагаар хаах;



13.1.4.энэ хуулийн 8.1.1-8.1.3, 8.1.5-8.1.12-т заасныг зөрчсөн бол иргэнийг 50000 төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, хууль бусаар олсон орлогыг хураах;

13.1.5.энэ хуулийн 8.1.4-т заасныг зөрчсөн бол албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;

13.1.6.энэ хуулийн 9.1-д заасныг зөрчсөн бол иргэнийг, хэрэв зөрчил гаргагч нь насанд хүрээгүй бол түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг 50000 төгрөгөөр торгох;

13.1.7.энэ хуулийн 9.2-т заасныг зөрчсөн бол албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, энэ хуулийн 9.3-т заасныг зөрчсөн бол хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох.”

4 дүгээр зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “тасралтгүй нэмэгдүүлэх” гэснийг “Тамхины хяналтын суурь конвенцид заасан түвшинд хүргэх” гэж, 6 дугаар зүйлийн 6.7.6 дахь заалтын “гэж бичсэн” гэснийг “гэсэн утгатай үг бичих буюу түүнтэй адилтгах лого, өнгө, брэндийн дүрс, тэдгээрийн хослол хэрэглэх;” гэж, 6.7.7 дахь заалтын “18” гэснийг “21” гэж, 8 дугаар зүйлийн гарчгийг “Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглох” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн дугаарыг “13.3” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2013 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 11 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 43.1.4 дэх заалт нэмсүгэй:

“43.1.4.зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагар саналаа гаргасан сонгогчдын саналын хуудсыг санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийх.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийн “20.00” гэснийг “22.00” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2012 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 11 дүгээр
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1998 оны 7 дугаар сарын 30-ны өдөр баталсан “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс болон Кувейт Улс хоорондын Хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.



2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 11 дүгээр
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ
ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.2001 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр баталсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж оногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Вант Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 11 дүгээр
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ
ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.2002 оны 10 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улс, Нидерландын Вант Улс хоорондын Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Конвенцийг соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 11 дүгээр
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2003 оны 10 дугаар сарын 23-ны өдөр баталсан Монгол Улсын Засгийн газар, Арабын Нэгдсэн Эмират Улсын Засгийн газар хоорондын Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 11 дүгээр
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт:

“4.1.8.Их Эзэн Чингис хааны өдөр: Их Эзэн Чингис хаан мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 1.”

2/5 дугаар зүйлийн 5.1.16 дахь заалт:

“5.1.16.Бүгд Найрамдах Улс тунхагласан өдөр: 11 дүгээр сарын 26.”

2 дугаар зүйл. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.”



3 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 11 дүгээр
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн 76 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 76.1.7, 76.1.8 дахь заалт нэмсүгэй:

“76.1.7.Их Эзэн Чингис хааны өдөр: Их Эзэн Чингис хаан мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 1;

76.1.8.Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр: арван хоёрдугаар сарын 29.”

2 дугаар зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 10 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 98

Улаанбаатар
хот

**Засгийн газрын комисс, хороо,
үндэсний зөвлөл, ажлын хэсгийн
бүрэлдэхүүний тухай**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 6.1, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 20.3, Цөмийн энергийн тухай хуулийн 10.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23.2, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14.6, Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 6.3, Үндэсний их баяр наадмын



тухай хуулийн 11.1.3, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18.2, Усны тухай хуулийн 9.1.5, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 7.3, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 8.1.2, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 8.3, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.2, Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гаалийн тарифын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Стандартчиллын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, Цөмийн энергийн комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар, Улсын онцгой комиссын бүрэлдэхүүнийг 4 дүгээр, Мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн эргэлтэд хяналт тавих үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 5 дугаар, Төрийн хэлний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 6 дугаар, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг 7 дугаар, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнийг 8 дугаар, Архивын салбарт хамтран ажиллах Монгол Улс, Оросын Холбооны Улсын хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг 9 дүгээр, Хэмжил зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 10 дугаар, Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 11 дүгээр, Усны үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 12 дугаар, Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөлийн Монголын талын хэсгийн бүрэлдэхүүнийг 13 дугаар, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 14 дүгээр, Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 15 дугаар, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 16 дугаар, Тогтвортой хөгжлийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 17 дугаар, Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 18 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах орон тооны бус Засгийн газрын комисс, хороо, зөвлөл, ажлын хэсэг болон тэдгээрийн даргыг 19 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

3. Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах энэ тогтоолын 19 дүгээр хавсралтаар баталсан орон тооны бус комисс, хороо, зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг холбогдох Засгийн газрын гишүүн болон Засгийн газрын агентлагийн даргатай зөвшилцсөний үндсэн дээр шинэчлэн баталж ажиллуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай.



4. Байнгын үйл ажиллагаатай, орон тооны бус Засгийн газрын комисс, хороо, зөвлөл, ажлын хэсгийг байгуулахдаа энэ тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

5. Засгийн газраас баталсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий зөвлөл, комисс, хороо, ажлын хэсгийг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн ахалж, хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнг Засгийн газарт танилцуулж байхаар тогтоосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “...хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралт ёсоор” гэсэн хэсэг, “Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлах тухай” Засгийн газрын 2006 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 314 дүгээр тогтоол, “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2007 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 159 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн “...хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах хорооны бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор” гэсэн хэсэг, “Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 40 дүгээр тогтоол, “Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2009 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “...хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд уялдуулах үүрэг бүхий зохицуулах хорооны бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралт ёсоор” гэсэн хэсэг, “Чөлөөт бүсийн зөвлөл байгуулах тухай” Засгийн газрын 2009 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 37 дугаар тогтоол, “Зөвлөл байгуулах тухай” Засгийн газрын 2009 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 48 дугаар тогтоол, “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 82 дугаар тогтоол, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2011 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 7 дугаар тогтоол, “Удирдах хороо байгуулах тухай” Засгийн газрын 2011 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 144 дүгээр тогтоол, “Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрэм, ажлын албаны орон тоог батлах тухай” Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 323 дугаар тогтоолын 1 зүйлийн “Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, ...” гэсэн хэсэг, “Биржийн зохицуулах зөвлөлийн гишүүдийг томилох, дүрэм, журам батлах тухай” Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 188 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөлийн гишүүдийг 1 дүгээр хавсралт ёсоор томилж,” гэсэн хэсэг, “Зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай” Засгийн газрын 2012 оны



7 дугаар сарын 18-ны өдрийн 234 дүгээр тогтоол, “Цөмийн энергийн комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 81 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.САЙХАНБИЛЭГ

Засгийн газрын 2012 оны 98 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ГААЛИЙН ТАРИФЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Сангийн сайд
Орлогч дарга	-Эдийн засгийн хөгжлийн дэд сайд
Гишүүд:	-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга (тохиролцсоноор); -Гаалийн ерөнхий газрын дарга; -Татварын ерөнхий газрын дарга; -Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал; -Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга; -Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Зам, тээврийн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга; -Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга; -Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;



<p>Нарийн бичгийн дарга</p>	<ul style="list-style-type: none"> -Эдийн засгийн хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, зохицуулалтын газрын дарга; -Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга (тохиролцсоноор); -Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын төлөөлөл; -Төрийн бус байгууллагын төлөөлөл. -(Орон тооны).
<p>Засгийн газрын 2012 оны 98 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт</p>	
<p>СТАНДАРТЧИЛЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН</p>	
<p>Дарга</p> <p>Гишүүд:</p>	<ul style="list-style-type: none"> -Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга -Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга; -Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга; -Оюуны өмчийн газрын дарга; -Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга; -Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга; -Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Боловсрол, шинжлэх ухааны яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;



- Зам, тээврийн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
- Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
- Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Хөдөлмөрийн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлого, зохицуулалтын газрын дарга;
- Эдийн засгийн хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, зохицуулалтын газрын дарга;
- Эрчим хүчний яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
- Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч;
- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэд дарга (тохиролцсоноор);
- Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн (тохиролцсоноор).
- Стандартчилал, хэмжил зүйн газрын ажилтан.

Нарийн бичгийн дарга

Засгийн газрын 2012 оны 98 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга** -Монгол Улсын Ерөнхий сайд
- Орлогч дарга** -Цөмийн энергийн газрын дарга
- Гишүүд:**
 - Байгаль орчин, ногоон хөгжлийн дэд сайд;
 - Гадаад харилцааны дэд сайд;



<p>Нарийн бичгийн дарга</p>	<ul style="list-style-type: none"> -Уул уурхайн дэд сайд; -Эрчим хүчний дэд сайд; -Эдийн засгийн хөгжлийн дэд сайд; -Тагнуулын ерөнхий газрын дарга; -Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга. -Цөмийн энергийн газрын Цөмийн технологийн газрын дарга.
<p>Засгийн газрын 2012 оны 98 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт</p>	
<p>УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН</p>	
<p>Дарга</p>	<p>-Монгол Улсын Шадар сайд</p>
<p>Орлогч дарга</p>	<p>-Онцгой байдлын ерөнхий газрын дарга</p>
